



Долоо хоног тутмын хэвлэл
2016 оны 10 дугаар сарын 27
№ 40 /949/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын
Засгийн газрын
тогтоол

2114

Монгол Улсын
Засгийн газрын
тогтоол

2116

**Хүүхдийн мөнгө олгох арга
хэмжээний тухай**

**“Боловсролын зээлийн сан”
байгуулах талаар авах арга
хэмжээний тухай**

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

732.	Тогтоолын үйлчлэлийг түдгэлзүүлэх тухай	Дугаар 90	2113
733.	Хүүхдийн мөнгө олгох арга хэмжээний тухай	Дугаар 98	2114
734.	Тогтоолд өөрчлөлт оруулах тухай	Дугаар 109	2115
735.	“Боловсролын зээлийн сан” байгуулах талаар авах арга хэмжээний тухай	Дугаар 111	2116

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2016 оны 9 дүгээр
сарын 14-ний өдөр

Дугаар 90

Улаанбаатар
хот

Тогтоолын үйлчлэлийг түдгэлзүүлэх тухай

Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Арьс, ширний үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт батлах тухай” Засгийн газрын 2013 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн 300 дугаар тогтоолын үйлчлэлийг 2016 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн 2017 оны 8 дугаар сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд түр түдгэлзүүлсүгэй.

2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллан, дүнг 2017 оны 7 дугаар сард багтаан Засгийн газарт танилцуулахыг Монгол Улсын Шадар сайд У.Хүрэлсүх, Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэн нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Ж.ЭРДЭНЭБАТ

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН
ҮЙЛДВЭРИЙН САЙД**

П.СЭРГЭЛЭН



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2016 оны 9 дүгээр
сарын 21-ний өдөр

Дугаар 98

Улаанбаатар
хот

Хүүхдийн мөнгө олгох арга хэмжээний тухай

Хүний хөгжил сангийн тухай хуулийн 15.3, Хүний хөгжил сангийн 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Улсын Их Хурлын 2015 оны 103 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. 2016 оны 7-12 дугаар сард хүүхдийн мөнгө авах 0-18 насны хүүхдийн нэрсийг тухай бүр гарган Сангийн яаманд хүргүүлж байхыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Н.Номтойбаярт даалгасугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Засгийн газрын 2012 оны 70 дугаар тогтоолоор баталсан “Хүний хөгжил сангаас хүүхдэд мөнгө олгох журам”-ын 4 дүгээр зүйлд дор дурдсан агуулга бүхий дараах хэсэг, заалтыг нэмсүгэй:

1/ 4 дүгээр зүйлийн 4.2.5, 4.2.6 дахь заалт:

“4.2.5. тухайн өрхийн ам бүлийн тоо гурав болон түүнээс дээш гишүүнээр өөрчлөгдсөн;

4.2.6. хүүхдийн мөнгө авч байгаа өрх нь сум, дүүрэг, аймаг хооронд шилжилт хөдөлгөөн хийсэн.”

2/ 4 дүгээр зүйлийн 4.7 дахь хэсэг:

“4.7. Энэ журмын 4.2.5, 4.2.6-д заасны дагуу хүүхдийн мөнгөний олголтыг түр зогсоосон өрхийн мэдээллийг шинэчилсний дараа тухайн өрх нь хүүхдийн мөнгө авах нөхцөлийг хангаж байвал үргэлжлүүлэн олгох бөгөөд түр зогсоосон хугацааны мөнгийг нөхөн олгоно.”

Энэ тогтоолыг 2016 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй..

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Ж.ЭРДЭНЭБАТ

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД**

Н.НОМТОЙБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2016 оны 10 дугаар
сарын 5-ны өдөр

Дугаар 109

Улаанбаатар
хот

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Онцгой албан татварын тухай хуулийн 6.7-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Автобензин, дизелийн түлшний гааль, онцгой албан татварын тухай” Засгийн газрын 2015 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн 18 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийг дор дурдсанаар өөрчилсүгэй:

№	Хилийн боомтын нэр	Ногдуулах онцгой албан татварын хэмжээ (төгрөгөөр)		
		Автобензин (шинжилгээний аргаар тодорхойлсон октаны хэмжээ)		Дизелийн түлш
		90 хүртэл	90 болон түүнээс дээш	
1	Цагааннуур, Ярант, Боршоо, Арцсуурь, Тэс, Бургастай, Гашуунсухайт, Шивээхүрэн, Баянхошуу, Бичигт, Хавирга	0	0	0
2	Ханх, Ульханмайхан	0	0	0
3	Сүхбаатар, Замын-Үүд, Алтанбулаг	260,000.0	260,000.0	280,000.0
4	Эрэнцав	130,000.0	130,000.0	150,000.0

2. Дотоодын зах зээлд борлуулж байгаа автобензин, дизелийн түлшний жижиглэнгийн үнийг тогтвортой байлгах талаар холбогдох арга хэмжээг авч, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдоржид үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2015 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн 438 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэ тогтоолыг 2016 оны 10 дугаар 6-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД
САНГИЙН САЙД**

**Ж.ЭРДЭНЭБАТ
Б.ЧОЙЖИЛСҮРЭН**



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2016 оны 10 дугаар
сарын 5-ны өдөр

Дугаар 111

Улаанбаатар
хот

“Боловсролын зээлийн сан” байгуулах талаар авах арга хэмжээний тухай

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5.4.13, 6.4.6, 16.4, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 9.3-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Сургалтын төрийн санг “Боловсролын зээлийн сан” болгон өөрчлөн зохион байгуулж, орон тооны хязгаар, цалингийн санг баталж мөрдүүлэхийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ж.Батсуурь, Сангийн сайд Б.Чойжилсүрэн нарт тус тус даалгасугай.

2. “Боловсролын зээлийн сангийн дүрэм”-ийг 1 дүгээр хавсралт, “Боловсролын зээлийн сангийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн”-ийг 2 дугаар хавсралт, “Оюутны хөгжлийн зээлийн журам”-ыг 3 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

3. Засгийн газрын 2014 оны 71 дүгээр тогтоолоор баталсан “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид суралцагчийн тэтгэлэг олгох журам”-д дор дурдсан агуулга бүхий 4.1.6 дахь заалт нэмсүгэй:

“4.1.6. Нэг өрхийн 3 болон түүнээс дээш хүүхэд дээд боловсролын сургалтын байгууллагад бакалаврын зэргийн боловсрол эзэмшихээр зэрэг суралцаж байгаа тохиолдолд 1 хүүхдийн.”

4. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ж.Батсуурь, Сангийн сайд Б.Чойжилсүрэн нарт тус тус даалгасугай.

5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Засгийн газрын 2012 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн 19 дүгээр тогтоолын 1, 2 дугаар хавсралт, 4 дүгээр хавсралтын 2 дугаар заалтыг хүчингүй болсонд тооцож, Засгийн газрын 2014 оны 71 дүгээр тогтоолоор баталсан “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид суралцагчийн тэтгэлэг олгох журам”-ын 4.4, 6.1, 6.2, 6.5, 6.6.2, 6.6.3 дахь заалтын “Сургалтын төрийн” гэснийг “Боловсролын зээлийн” гэж тус тус өөрчилсүгэй.;

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Ж.ЭРДЭНЭБАТ

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААН, СПОРТЫН САЙД**

Ж.БАТСУУРЬ

Засгийн газрын 2016 оны 111 дүгээр
тогтоолын 1 дүгээр хавсралт

БОЛОВСРОЛЫН ЗЭЭЛИЙН САНГИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Боловсролын зээлийн сан (цаашид “сан” гэх)-гийн зорилго нь дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид зохих журмын дагуу санхүүгийн дэмжлэг, суралцагчийн тэтгэлэг, сургалтын төлбөрийн зээл олгох, зээлийг эргэн төлүүлэх ажлыг зохион байгуулахад оршино.

1.2. Сангийн үйл ажиллагааг Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хууль болон энэхүү дүрмээр зохицуулна.

1.3. Сангийн үйл ажиллагааны зардлыг улсын төсөв болон зээлийн хүүгийн орлогоос санхүүжүүлнэ.

1.4. Сан нь тогтоосон журмын дагуу хийсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

1.5. Сангийн хөрөнгийг Төрийн сангийн тусгай дансанд байршуулах бөгөөд банкинд харилцах данстай байна.

Хоёр. Сангийн Удирдах зөвлөл

2.1. Сангийн үйл ажиллагааг Удирдах зөвлөл (цаашид “Зөвлөл” гэх) удирдана. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг Засгийн газар батална.

2.2. Зөвлөлийн үйл ажиллагааны хэлбэр нь хуралдаан байна.

2.3. Зөвлөл нь улиралд нэгээс доошгүй удаа хуралдана. Шаардлагатай тохиолдолд зөвлөлийн саналаар ээлжит бус хуралдааныг зарлан хуралдуулж болно.

2.4. Нийт гишүүдийн 75-аас доошгүй хувь оролцсоноор хуралдааныг хүчинтэйд тооцно.

2.5. Зөвлөл асуудлыг тухайн хуралдаанд оролцсон гишүүдийн 75-аас дээш хувийн саналаар шийдвэрлэж, тогтоол, тэмдэглэл гаргана. Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хуралдаанд оролцох боломжгүй гишүүн саналаа бичгээр өгсөн тохиолдолд түүнийг хуралдаанд оролцсонд тооцно.

2.6. Зөвлөлийн нарийн бичгийн дарга хэлэлцэх асуудлыг зөвлөлийн гишүүдэд 3 хоногийн өмнө бичгээр хүргүүлнэ.

2.7. Зөвлөл дараах эрх, үүрэгтэй байна:

2.7.1. сангийн үйл ажиллагааг удирдан зохицуулах;

2.7.2. сангийн үйл ажиллагааны болон сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх арга хэмжээний жилийн төлөвлөгөө, төсвийг хэлэлцэн батлах;

2.7.3. сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах талаар үүрэг даалгавар өгөх;

2.7.4. сангийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэн дүгнэлт өгөх;

2.7.5. сангаас олгосон зээлийг эргэн төлүүлэх асуудлыг шийдвэрлэх.



Гурав. Сангийн гүйцэтгэх захирал

3.1. Сангийн гүйцэтгэх захирал нь тус сангийн үйл ажиллагааг өдөр тутмын удирдлагаар хангаж, Зөвлөлийн хуралдаанаас гарсан шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах үйл ажиллагааг хариуцна.

3.2. Гүйцэтгэх захирлыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилж, чөлөөлнө.

3.3. Гүйцэтгэх захирал нь Сангийн хөрөнгийг зориулалтын дагуу хуваарилах, зарцуулах, хөрөнгийн ашиглалтад хяналт тавих, тайлагнах ажлыг зохион байгуулах, сангийн ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээ байгуулж дүгнэх, тэдгээрийн ажил, үүргийн хуваарийг батлах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

3.4. Сангийн ажлын албаны бүтэц, орон тоог боловсролын болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

Дөрөв. Сангийн хөрөнгийн эх үүсвэр, зарцуулалт

4.1. Сангийн хөрөнгө нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

4.1.1. улсын төсвийн хөрөнгө;

4.1.2. эргэн төлөгдсөн зээлийн төлбөр, зээлийн хүүгийн орлого;

4.1.3. хандив, тусламж.

4.2. Сангийн хөрөнгийг дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид олгох сургалтын төлбөрийн зээл, суралцагчийн тэтгэлэг, санхүүгийн дэмжлэг болон сангийн үйл ажиллагаатай холбоотой бусад зардлыг санхүүжүүлэхэд зарцуулна. Сангийн үйл ажиллагааны зардал нь зээлийн хүүгийн орлогын 2 хувиас илүүгүй байна.

4.3. Сангийн хөрөнгийг хууль, энэ журамд зааснаас бусад үйл ажиллагаанд зарцуулахыг хориглоно.

Тав. Сангийн эрх, үүрэг

5.1. Сан дараах эрхтэй байна:

5.1.1. сургалтын төлбөрийн зээлийн болон амьжиргааны зардлын тэтгэлэг олгох гэрээ байгуулах, сургалтын төлбөрийн зээл, тэтгэлэг олгох;

5.1.2. сургалтын төлбөрийн зээл, суралцагчийн тэтгэлэг авч байгаа суралцагчийн сурлага, шилжилт хөдөлгөөний талаарх мэдээлэл болон зээл, тэтгэлгийн зарцуулалтын тайланг дээд боловсролын сургалтын байгууллагаас авах;

5.1.3. сангийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах, төсөл хэрэгжүүлэх;

5.1.4. сургалтын төлбөрийн зээл, зээлийн гэрээний биелэлттэй холбоотой оролцогч банк болон дээд боловсролын сургалтын байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавих, шаардлагатай бол уг асуудлаар хуулийн байгууллагад хандах.

- 5.2. Сан дараах үүрэгтэй байна:
- 5.2.1. сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах;
 - 5.2.2. сангийн тухайн жилийн төсвийг боловсруулах;
 - 5.2.3. сургалтын төлбөрийн зээлийг олгох оролцогч банк болон дээд боловсролын сургалтын байгууллагуудтай гэрээ байгуулах;
 - 5.2.4. сургалтын төлбөрийн зээлийг эргэн төлүүлэх ажлыг зохион байгуулах, зээлийн барьцаанд байгаа хөрөнгийн баталгаа бүрдүүлэх;
 - 5.2.5. сургалтын төлбөрийн зээлийн гэрээг зөрчсөн тохиолдолд нэхэмжлэх гаргах;
 - 5.2.6. сургалтын төлбөрийн зээлийг төлөхөөс зайлсхийсэн этгээдэд гэрээ болон хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэх асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;
 - 5.2.7. сургалтын төлбөрийн зээл, тэтгэлэгт хамрагдах суралцагчдын бичиг баримтын бүрдүүлэлт, зээлийг эргэн төлүүлэх асуудлаар төрийн болон нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах;
 - 5.2.8. сангийн үйл ажиллагааны тайлан гаргах;
 - 5.2.9. сангийн санхүүжилтээр дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдын талаар мэдээллийн сан бүрдүүлэх.

Зургаа. Бусад

- 6.1. Сан нь үйл ажиллагаандаа жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэнэ.
- 6.2. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Засгийн газрын 2016 оны 111 дүгээр
тогтоолын 2 дугаар хавсралт

**БОЛОВСРОЛЫН ЗЭЭЛИЙН САНГИЙН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

- Дарга: -Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд
- Дэд дарга: -Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн дарга
- Гишүүд: -Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга;
-Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын боловсролын асуудал хариуцсан референт;
-Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Боловсролын бодлогын газрын дарга;



Нарийн бичгийн
дарга:

-Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын
яамны Санхүү, эдийн засгийн газрын дарга;
-Монголбанкны Мөнгөний бодлогын газрын
Бодлогын хэрэгжилт, зээлийн хэлтсийн захирал
(зөвшилцсөнөөр);
-Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн
дарга;
-Боловсролын зээлийн сангийн гүйцэтгэх
захирал.

Засгийн газрын 2016 оны 111 дүгээр
тогтоолын 3 дугаар хавсралт

ОЮУТНЫ ХӨГЖЛИЙН ЗЭЭЛИЙН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагад бакалаврын зэргийн боловсрол эзэмшихээр зохих журмын дагуу элсэн үндсэн сургалтын хэлбэрээр суралцаж байгаа Монгол Улсын иргэн (цаашид “оюутан” гэх)-д оюутны хөгжлийн зээл олгохтой холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Оюутны хөгжлийн зээлийн зорилго нь дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагч оюутны сурах бололцоог нэмэгдүүлэх, дээд боловсролын сургалтын байгууллагын сургалтын чанар, өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чиглэгдэнэ.

1.3. Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.3.1. “оюутны хөгжлийн зээл” гэж (цаашид “зээл” гэх) дээд боловсролын байгууллагад үндсэн сургалтын хэлбэрээр суралцаж байгаа суралцагчдын сургалтын төлбөрт нь зориулан олгож байгаа хөгжлийн зээлийг;

1.3.2. “оюутны хөгжлийн зээлийн хүү” гэж сургалтын төлбөрийн зээл олгох үйл ажиллагааг зохион байгуулахад шаардагдах зардлын хэмжээг;

1.3.3. “зээлийн хэмжээ” гэж оролцогч сургуулийн Удирдах зөвлөлөөс тогтоосон нэг кредит (багц цаг) цагийн үнэлгээг оюутны сонгосон хичээлийн нийт кредитээр үржүүлсэнд гарах хэмжээг;

1.3.4. “хүү бууруулах зээл” гэж оюутны сургалтын төлбөр төлөхөд зориулж өмнө олгогдсон зээлийн үлдэгдлийг шинэ нөхцөлтэй зээлд шилжүүлэх зээлийг;

1.3.5. “богино хугацаатай зээл” гэж тухайн хичээлийн жилийн сургалтын төлбөр төлөхөд зориулж авсан 1 жилийн хугацаанд эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийг;

1.3.6. “урт хугацаатай зээл” гэж Дээд боловсролын тухай хуульд заасан бакалаврын дээд боловсрол эзэмших үндсэн сургалтын 4-6 жилийн хугацаанд жил бүр сургалтын төлбөр төлөхөд зориулж авсан 10 хүртэлх жилийн хугацаанд эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийг;

1.3.7. “суралцах хугацаа” гэж Дээд боловсролын тухай хуульд заасан бакалаврын сургалтад шаардагдах үндсэн сургалтын хугацааг;

1.3.8. “оролцогч банк” гэж (цаашид “банк” гэх) сургалтын төлбөрийн зээл олгохоор Боловсролын зээлийн сантай гэрээ байгуулсан банкийг;

1.3.9. “оролцогч сургууль” гэж (цаашид “сургууль” гэх) Боловсролын зээлийн сантай гэрээ байгуулсан, сургалт эрхлэх тусгай зөвшөөрөлтэй, байгууллагын магадлан итгэмжлэгдсэн дээд боловсролын сургалтын байгууллагыг;

1.3.10. “оюутны гэр бүлийн гишүүн” гэдэгт эцэг, эх, эмээ, өвөө, төрсөн ах, эгч, дүү, асран хамгаалагчийг.

Хоёр. Зээлийн санхүүжилт

2.1. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь зээлийн санхүүжилтийг Боловсролын зээлийн сангийн төсөвт тусгана.

2.2. Боловсролын зээлийн сан зээлийг арилжааны банкаар дамжуулж олгоно.

2.3. Зээлийн эргэн төлөлтийн эрсдэлийг арилжааны банк хариуцна.

2.4. Зээлийн эргэн төлөлтөөс тодорхой хувиар тооцож Боловсролын зээлийн сангийн эргэлтийн хөрөнгийн хуримтлалыг бүрдүүлнэ.

2.5. Зээлийн эргэлтийн хөрөнгийн хуримтлалыг Боловсролын зээлийн санд бүрдэх хүртэл хугацаанд улсын төсвөөс санхүүжүүлнэ.

2.6. Зээлийн эргэлтийн хөрөнгийг Боловсролын зээлийн сангаас улсын төсөвт буцаан төвлөрүүлэхгүй.

Гурав. Талуудын эрх, үүрэг

3.1. Төрийн захиргааны төв байгууллага дараах эрх, үүрэгтэй байна:

3.1.1. боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зээлийн төсвийн төслийг хянан санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

3.1.2. санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага Боловсролын зээлийн сангийн төсвийг хянаж батлуулах, санхүүжүүлэх.

3.2. Боловсролын зээлийн сан дараах эрх, үүрэгтэй байна:

3.2.1. зээлийн төсвийн төсөл боловсруулж батлуулах;

3.2.2. зээлийн санхүүжилтийг зарцуулах, хянах;

3.2.3. 2 хувийн хүүтэй зээлийг банкинд олгох;



- 3.2.4. зээлийн эргэлтийн хуримтлалыг бүрдүүлэх;
- 3.2.5. оролцогч банк болон сургуультай хамтран ажиллах гэрээ байгуулах;
- 3.2.6. зээлийн санхүүжилттэй холбоотой үйл ажиллагааг зохион байгуулах;
- 3.2.7. зээлийн санхүүжилтийн тайлан гаргах;
- 3.2.8. зээлийн талаарх банкны тайланг хүлээн авч хянан нэгтгэх;
- 3.2.9. боловсролын болон санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад зээлийн тайланг нэгтгэж, тайлагнах.
- 3.3. Банк дараах эрх, үүрэгтэй байна:
- 3.3.1. Боловсролын зээлийн сан, сургуультай хамтран ажиллах гэрээ байгуулах;
- 3.3.2. оюутанд жилийн 5 хувийн хүүтэй зээл олгох;
- 3.3.3. зээлийн эрсдэлийг бүрэн хариуцах;
- 3.3.4. оюутанд олгосон зээлийн 5 хувиар тухайн сургуулийн зээлийн эрсдэлийн сан бүрдүүлэх, зээлийн гэрээний гүйцэтгэлийг дүгнэх;
- 3.3.5. оюутанд олгосон зээлийг сургуулийн дансанд шилжүүлэх;
- 3.3.6. зээлийн талаар сургууль, оюутан, эцэг эх, олон нийтэд сурталчлах, таниулах ажлыг Боловсролын зээлийн сан, сургуультай хамтран зохион байгуулах;
- 3.3.7. зээлийн санхүүжилтийн тайланг долоо хоног, сар, улирал, жил тутам гаргаж санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, Боловсролын зээлийн санд тус тус хүргүүлэх;
- 3.3.8. зээл авахад үйлчилгээний шимтгэл, хураамж авахгүй байх.
- 3.4. Сургууль дараах эрх, үүрэгтэй байна:
- 3.4.1. Боловсролын зээлийн сан, банктай хамтран ажиллах гэрээ байгуулах;
- 3.4.2. зээлийн болон эрсдэлийн дансыг банкинд байршуулах;
- 3.4.3. банкинд байршуулсан сургалтын төлбөрийн орлогын дансыг өөр банкинд шилжүүлэхгүй байх;
- 3.4.4. зээлийн 5 хувийг банкин дахь сургуулийн эрсдэлийн дансанд байршуулах;
- 3.4.5. боловсролын нэгдсэн мэдээллийн санд сургалтын хөтөлбөр, оюутны шилжилт хөдөлгөөн, дүн, холбогдох бусад мэдээллийг тогтоосон хугацаанд оруулах;
- 3.4.6. төгсөгчдийн тандалтын судалгаа хийх;
- 3.4.7. зээлийн талаар сургууль, суралцагч, эцэг эх, олон нийтэд таниулах ажлыг зохион байгуулах.

3.5. Оюутны эрх, үүргийг банк, оюутан хооронд байгуулах зээлийн гэрээнд тусгана.

Дөрөв. Зээлийн нөхцөл, шаардлага

4.1. Энэ журмын хүрээнд дараах 3 төрлийн зээлийг олгоно:

4.1.1. хүү бууруулах зээл;

4.1.2. богино хугацаатай зээл;

4.1.3. урт хугацаатай зээл.

4.2. Энэ журмын 4.1-д заасан зээлийн хүү жилийн 5 хувь байна.

4.3. Зээлийг дараах хугацаагаар олгоно:

4.3.1. хүү бууруулах зээлийн хугацаа цалин, тэтгэврийн зээлийн дуусах хугацаатай тэнцүү;

4.3.2. богино хугацаатай зээлийн хугацаа 12 сар хүртэл;

4.3.3. урт хугацаатай зээлийн хугацаа 10 жил хүртэл.

4.4. Зээлд хамрагдах оюутан дараах ерөнхий шаардлагыг хангасан байна:

4.4.1. магадлан итгэмжлэгдсэн сургуульд зохих журмын дагуу элссэн батламжтай байх;

4.4.2. боловсролын нэгдсэн мэдээллийн санд бүртгэгдсэн байх;

4.4.3. зээлийн үндсэн зээлдэгч нь оюутан, хамтран зээлдэгч нь оюутны гэр бүлийн гишүүн байх.

4.5. Хүү бууруулах болон богино хугацаатай зээлд хамрагдах оюутан энэ журмын 4.4-т заасан ерөнхий шаардлагаас гадна дараах шаардлагыг хангасан байна.

4.5.1. дээд боловсролын сургалтын байгууллагад шинээр элсэн орсон оюутны хувьд тухайн сургуулийн хөтөлбөрт элсэх журамд заасан хичээлийн элсэлтийн ерөнхий шалгалтын оноо 400 буюу түүнээс дээш, бусад оюутны хувьд сурлагын голч дүн нь 2.0 болон түүнээс дээш байх;

4.5.2. сургуулийн сургалтын төлбөр төлсөн баримтын хуулбар (эх хувиар);

4.6. Урт хугацаатай зээлд хамрагдах оюутан энэ журмын 4.4-т заасан ерөнхий шаардлагаас гадна дараах шаардлагыг хангасан байна.

4.6.1. их, дээд сургууль төгссөнөөс хойш 4-6 жил хүртэл хугацаанд эргэн төлөх;

4.6.2. зээлийн эргэн төлөлт нь оюутны ирээдүйн орлогод суурилах;

4.6.3. зээлийн хүүгийн төлбөрийг зээл авсанаас хойш сар бүр, үндсэн төлбөрийг сургууль төгссөнөөс хойш 1 жилийн дараагаас эхлэн 3-5 жилийн хугацаанд төлөх;

4.6.4. зээлийн давтамж үндсэн сургалтын 4-6 жилийн хугацаанд жилд 2 хүртэлх удаа байх;



4.6.5. дээд боловсролын сургалтын байгууллагад шинээр элсэн орсон оюутны хувьд тухайн сургуулийн хөтөлбөрт элсэх журамд заасан хичээлийн элсэлтийн ерөнхий шалгалтын оноо 650 буюу түүнээс дээш, тэргүүлэх ач холбогдолтой мэргэжлийн чиглэлээр суралцаж байгаа оюутны сурлагын голч дүн 2.3, бусад оюутны сурлагын голч дүн 3.0 болон түүнээс дээш байх.

4.7. Зээлд хамрагдах оюутан дараах бичиг баримтыг бүрдүүлж банкинд хандана:

4.7.1. зээл хүссэн өргөдөл;

4.7.2. иргэний болон оюутны үнэмлэхийн нотариатаар баталгаажуулсан хуулбар;

4.7.3. сургуулийн сургалтын төлбөрийн нэхэмжлэл (эх хувиар);

4.7.4. хамтран зээлдэгч гэр бүлийн гишүүний иргэний үнэмлэхийн нотариатаар баталгаажуулсан хуулбар;

4.7.5. сургуульд зохих журмын дагуу элссэнийг гэрчлэх батламжийн нотариатаар баталгаажуулсан хуулбар.

Тав. Мэдээлэл, тайлан

5.1. Боловсролын зээлийн сан нь зээлийн мэдээллийг боловсролын нэгдсэн мэдээллийн санд бүртгэнэ.

5.2. Банк нь зээлийн мэдээллийг гэрээнд заасан хугацааны дагуу санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, Боловсролын зээлийн санд тус тус хүргүүлнэ.

Зургаа. Хяналт, хариуцлага

6.1. Банкинд олгосон зээлийн эх үүсвэрийн зориулалт, эргэн төлөлтөд санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хяналт тавина.

6.2. Боловсролын зээлийн сан нь оролцогч талуудын хооронд байгуулсан гэрээний биелэлтэд хяналт тавина.

6.3. Санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага шаардлагатай тохиолдолд зээлийн эх үүсвэрийн бүрдүүлэлт, ашиглалтад хяналт, шалгалт хийнэ.

6.4. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medecelel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 0.75

Индекс: 14003